

2022-2024 онд шинээр
нийлүүлэгдсэн
эмнэлгийн тоног
төхөөрөмжүүд



2022 он

2022.11.18-ны өдөр Өмнөговь аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газрын санаачилга, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн эрүүл мэндийн төслийн хүрээнд хүүхдийн ходоодны дуран, хүчилтөрөгчийн хамгийн сүүлийн үеийн иж бүрэн барокамер нийлүүлэгдсэн.



2022 оны 11-р сард БОЭТ чих хамар хоолойн үзлэгийн зориулалтын тоноглогдсон ширээ, сандал дагалдах багаж, дурангууд нийлүүлсэн



2022 он

БОЭТ-н Хүүхдийн тасагт ОНТХөрөнгөөр нийт 19 сая төгрөгийн өртөг бүхий 11 нэр төрлийн 24ш тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. /Эх хүүхдийн хөтөлбөр/



Манлай сумын ЭМТ-д 96,4 сая төгрөгийн ЭХО аппарат дагалдах хэрэгслийн хамт нийлүүлсэн.



2022 он

Цогтцэций сумын ЭМТ-д нийт 50 сая төгрөгийн санхүүжилтээр гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.



2022 онд Номгон СЭМТ-д орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 65сая төгрөг бүхий 19 нэр төрлийн 21 багаж, тоног төхөөрөмж, мөн 39,900.000 төгрөгийн өртөг бүхий хэт авиан аппарат нийлүүлэгдсэн.



2023 он

Хавдрыг эрт илрүүлэх ажлын хүрээнд: Нийт 110,000,000 төгрөгийн төсөв бүхий 4ш кольпоскопийг БОЭТ, Гурвантэс, Цогтцэций, Шимбилэг ЭМБ-уудад хүлээлгэн өгсөн.

БОЭТ-д харшлын кабинетийн тохижилт, тоног төхөөрөмж худалдаж авах ажлын хүрээнд 2023 оны 10-р сарын 11нд харшлын кабинетэд 12 нэр төрлийн 13ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг нийлүүлсэн.



2023 он


Өнө-орших ӨЭМТ, Эрүүл мэндийн газарт 7-р сарын 10-нд нийт 76,000,000 төгрөгийн төсөв бүхий шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүрэн нийлүүлж хяналтын камер, архивын шүүгээг суурилуулсан.

ОНТөсвөөр БОЭТ-д компьютерт томограф аппарат шинээр нийлүүлэгдсэн ба 2,8 тэрбумын төсвөөр гэрээ хийн сүүлийн үеийн Canon брендийн 160 зүслэгт томографыг 2023 оны 10-р сарын 13-нд БОЭТ-д ашиглалтын сургалтыг хийж, бүрэн суурилуулж хүлээлгэн өгсөн.



2023 он

ОНТөсвөөр БОЭТ-ийн эмчилгээ оношилгоонд шаардлагатай пиброскан төхөөрөмжийг 7-р сарын 23нд нийлүүлсэн ба нийт 349,700,000 төгрөгийн төсөв бүхий аппаратыг ашиглалтын сургалт хийж БОЭТ-д хүлээлгэн өгсөн.



Wato ex маркын унтуулгын аппаратны иж бүрдлийг 56,980,000 төгрөгийн төсвөөр 6-р сард нийлүүлж ашиглалтын сургалтыг хийж ашиглалтад оруулсан. Мөн нүдний оношилгооны тоног төхөөрөмжийг 40,660,000 төгрөгөөр гэрээний хугацаанд буюу 6-р сард нийлүүлж ашиглалтад өгсөн.



2023 он

Эрт илрүүлгийн нэгжид шаардлагатай тоног
төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд:
49,000,000 сая төгрөгийн төсөв бүхий
ходоодны уян дурангийн ариутгалын аппаратыг
БОЭТ-ийн дурангийн нэгжид 5-р сарын 15нд
нийлүүлж байнгын ашиглалтад оруулсан



БОЭТ-ийг Элэгний мэс заслын багаж
хэрэгслээр хангах ажлын хүрээнд 49,928,000
төгрөгийн гэрээ хийж 2023 оны 4-р сарын 10-
нд БОЭТ-ын мэс заслын тасагт нийлүүлж
байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.
Ингэснээр орон нутгийн хэмжээнд өмнө нь
хийгдэх боломжгүй байсан элэгний шалтгаант
төрөл бүрийн мэс заслыг амжилттай явуулах
боломж бүрдсэн.


2023 он

Сумын ЭМТ-үүдийн эмчилгээ оношилгоонд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд 550 сая төгрөгийн төсөв бүхийн 13 нэр төрлийн 37ш эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжүүдийг 2023 оны 12-р сард нийлүүлж ашиглалтын сургалтыг хийн хүлээлгэн өгсөн.



2023 он

Орон нутгийн төсвөөр 48,726,000 төгрөгийн хиймэл оюун ухааны тоног төхөөрөмжийг 2023 оны 6-р сарын 23-нд ашиглалтын сургалтыг хийж БОЭТ-д хүлээлгэн өгсөн.



2024 он

2024 оны 6-р сарын 11-нд БОЭТ-ийн дурангийн кабинетэд olympus HQ-190 маркын ходоодны дуранг, дагалдах нэг удаагийн хэрэгслийн хамт хүлээн авч комисс ажилласан. Тус дуран нийлүүлэгдсэнээр БОЭТ 3 ээлжийн ходоодны уян дурантай болж иргэдийн оношилгоонд хамрагдах хүлээгдэл багасах юм.



2024 он

- Орон нутгийн төсвөөр 2024 оны 11-р сард 49.026.000 төгрөгийн төсвөөр умайн хүзүүний хавдрыг эрт үед нь илрүүлэх хиймэл оюун ухааны аппаратыг Гурвантэс СЭМТ-д нийлүүлж ашиглалтад өгсөн.



2024 он

Нийт төсөв 618 сая. Хүрмэн СЭМТ-д 247.017.911 төгрөгийн төсвөөр нийт 59 нэр төрлийн 214 ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, Баяндалай СЭМТ-д 140.363.830 төгрөгийн төсвөөр нийт 35 нэр төрлийн 79 ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, Сэврэй СЭМТ-д 230.618.259 төгрөгийн төсвөөр нийт 87 нэр төрлийн 296ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл нийлүүлэгдсэн байна.



2024 он

- 400.000.001 төгрөгийн гэрээ хийсэн ба 2024 оны 10-р сарын 9-ний өдөр ЭМБ-уудад хүлээлгэн өгсөн. 13 ЭМБ-д нийт 33 нэр төрлийн 64ш эмнэлгийн тоног төхөөрөмжийг ЭМГ-ын даргын тушаалын дагуу хуваарилан өгсөн.



2024 он

6-р сарын 11-нд Төрөх эмэгтэйчүүдийн тасагт ургийн гажиг тодорхойлох боломжтой шинэ технологийн samsung V8 загварын ЭХО аппаратыг 395.175.000 төгрөгийн төсвөөр хүлээн ав ашиглалтад оруулсан. Ингэснээр орон нутагт ургийн гажгийг тодорхойлох бусад нарийн шинжилгээг хийх боломжтой болж байгаа юм.



2024 он

- 94 сая төгрөгийн төсвөөр зөөврийн рентген аппаратыг Сэврэй СЭМТ-д 2024 оны 5-р сард нийлүүлсэн.

